

## **Аж ахуйн нэгжийн бүрдүүлэх бичиг баримт**

**5.9. ЖДҮҮЭ нь дараах материалуудыг хавсаргасан байна.**

**5.9.1.** Зээлийн өргөдөл /сангаас баталсан загварын дагуу/

**5.9.2.** Захирлын иргэний үнэмлэхийн хуулбар;

**5.9.3.** Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, шаардлагатай бол тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар

**5.9.4.** Хуулийн этгээдийн хаягийн тодорхойлолт, үүсгэн байгуулагчийн дэлгэрэнгүй лавлагаа;

**5.9.5.** Барьцаалах үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн болон эзэмших эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ, газрын гэрээ, кадастрын зургийн хуулбар;

**5.9.6.** Хэрэв зээлийн хэвийн үлдэгдэлтэй бол зээлийн гэрээ, зээлийн дансны баталгаажсан хуулга, зээлийн эргэн төлөлтийн хуваарийн хуулбар;

**5.9.7.** Сүүлийн хоёр жилийн санхүүгийн баталгаажсан тайлан. Хэрэв 2 жилийн дотор байгуулагдсан бол байгуулагдсанаас хойших санхүүгийн баталгаажсан тайлан, шинээр үүсгэн байгуулагдсан бол эхлэлтийн баланс;

**5.9.8.** Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчээр бүртгүүлсэн тухай тухайн жилийн тодорхойлолт;

**5.9.9.** Нийгмийн даатгалд хамруулсан ажилтны тоо, төлж байгаа шимтгэлийн хэмжээ болон нийгмийн даатгалын байгууллагад хугацаа хэтэрсэн өр төлбөргүй талаарх тодорхойлолт;

Жич: Нийгмийн даатгалд хамруулсан ажилчдын тоо, шимтгэлийн хэмжээ, хугацаа хэтэрсэн өргүй төлбөрийг тодорхойлолт дээр заавал тусгасан байх.

**5.9.10.** Төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгэгдээгүй талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт;

**5.9.11.** Төлсөн татварын хэмжээ болон татварын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй талаарх харьяа татварын албаны тодорхойлолт;

Жич: Төлсөн татварын хэмжээ, хугацаа хэтэрсэн өргүй төлбөрийг тодорхойлолт дээр тусгасан байх.

**5.9.12.** Энэ журмын 5.2.4-т заасныг нотлох баримт;

\* 5.2.4.Төслийн нийт хөрөнгө оруулалтын 30.0-аас доошгүй хувийг өөрийн эх үүсвэрээс бүрдүүлэхээр санхүүгийн тооцоололд тусгасан байх;

**5.9.13.** Тухайн төсөл болон төсөл хэрэгжүүлэгчийн талаарх мэдээллийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг зөвшөөрснийг илэрхийлсэн мэдэгдэл.